



I-III/2022

Тархаасан: 2022 оны 4 дүгээр сарын 14



## Бүх төрлийн тээврийн зорчигч өмнөх оны мөн үеэс 2.1 дахин өслөө

### Бүх төрлийн тээвэр

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2022 оны эхний улиралд 9.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 7.2 (42.2%) сая тонноор буурсан байна. Энэхүү бууралтад авто тээврээр тээсэн ачаа 5.3 (59.4%) сая тонноор буурсан нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2022 оны эхний улиралд 41.0 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 21.2 (2.1 дахин) сая хүнээр өссөн байна. Зорчигчдын тоо өсөхөд авто тээврээр зорчигчид 20.7 (2.0 дахин) сая хүнээр өссөн нь голлон нөлөөлжээ.

#### ХҮСНЭГТ 1. БҮХ ТӨРЛИЙН ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар

Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2022* I-III	
Тээсэн ачаа, сая тонн	10.2	17.0	9.9	Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний улиралд, өмнөх улирлаас 600.9 (5.7%) мянган тонн, зорчигчид 8.3 (16.9%) сая хүнээр буурсан байна.
Зорчигчид, сая хүн	29.1	19.8	41.0	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	311.9	351.3	301.8	

Бүх төрлийн тээврийн орлого 2022 оны эхний улиралд 301.8 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 49.5 (14.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Авто тээврийн орлого 24.2 (18.7%) тэрбум төгрөгөөр буурсан нь бүх төрлийн тээврийн орлого буурахад нөлөөлсөн байна. Мөн бүх төрлийн тээврийн орлого 2022 оны эхний улиралд өмнөх улирлаас 51.7 (14.6%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

#### Авто замын тээвэр

Авто тээврээр 2022 оны эхний улиралд 3.6 сая тонн ачаа, давхардсан тоогоор 40.5 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 5.3 (59.4%) сая тонноор буурсан бол зорчигчид 20.7 (2.0 дахин) сая хүнээр өссөн байна.

Ачаа тээврийн бууралтад уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 5.6 сая тонн буюу 67.9 хувь буурсан нь нөлөөлсөн бол зорчигч тээврийн өсөлтөд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 20.6 (2.2 дахин) сая хүнээр өссөн нь нөлөөлсөн байна.

Харин авто тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний улиралд өмнөх улирлаас 620.3 (20.7%) мянган тонноор өссөн бол зорчигчид 8.4 (17.2%) сая хүнээр буурсан байна.

ХҮСНЭГТ 2. АВТО ТЭЭВРИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ,  
жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар


Үзүүлэлт	2020 I-III	2021 I-III	2022* I-III	Авто тээврийн салбарын орлого 2022 оны эхний улиралд 105.5 тэрбум төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 24.2 (18.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого буурсан нь голлон нөлөөлсөн байна.
Тээсэн ачаа, сая тонн	3.1	8.9	3.6	
Уул уурхайн бүтээгдэхүүн	2.5	8.2	2.6	
Зорчигчид, сая хүн	28.5	19.8	40.5	
Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчид	25.4	17.1	37.7	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	85.9	129.7	105.5	

Мөн авто тээврийн орлого 2022 оны эхний улиралд өмнөх улирлаас 4.2 (4.2%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

### Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2022 оны эхний улиралд 6233.0 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1885.0 (23.2%) мянган тонноор буурчээ.

ЗУРАГ 1. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА,  
сараар, мянган тонн



Төмөр замын тээврээр тээсэн ачааны бууралтад экспортын ачаа 1397.1 (49.0%) мянган тонн, дотоод ачаа 261.1 (7.8%) мянган тонноор тус тус буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2022 оны 3 дугаар сард 2278.2 мянган тонн болж, өмнөх сараас 302.7 (15.3%) мянган тонноор өссөн байна.

Энэхүү өсөлтөд барилгын материал 201.2 (4.0 дахин) мянган тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

ХҮСНЭГТ 3. ТӨМӨР ЗАМААР ДОТООД, ГАДААДАД ТЭЭСЭН АЧАА, жил бүрийн 1 дүгээр улирлын байдлаар, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар


Үзүүлэлт	2020 I-III	2021* I-III	2022* I-III
<b>Бүгд</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>	<b>100.0</b>
Уул уурхайн бүтээгдэхүүн	92.5	84.7	86.4
Барилгын материал	2.3	9.9	8.5
Мод, модон материал	0.4	0.4	0.3
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	0.8	1.1	0.8
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.1	1.3	0.5
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.0	0.7	1.3
Бусад	1.9	1.9	2.1

Төмөр замаар 2022 оны эхний улиралд тээсэн ачаа өмнөх оны мөн үеэс уул уурхайн бүтээгдэхүүн 1328.2 (25.3%) мянган тонн, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн 54.5 (69.9%) мянган тонн, барилгын материал 227.7 (37.1%) мянган тонноор буурч, харин хар төмөр 15.6 (34.7%) мянган тонноор өссөн байна.

Цар тахлын нөхцөл байдлын улмаас өнгөрсөн оны мөн үед төмөр замын зорчигч тээврийн үйл ажиллагааг хязгаарласан байсан бол төмөр замын тээврээр зорчигчид 2022 оны эхний улиралд 354.1 (давхардсан тоо) мянга болж, өмнөх улирлаас 64.2 (22.2%) мянган зорчигчоор өссөн байна. Төмөр замын тээврээр зорчигчид өсөхөд орон нутгийн зорчигч тээврийн хөдөлгөөнийг нээсэн нь голлон нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврээр зорчигчид 2022 оны 3 дугаар сард 131.8 (давхардсан тоо) мянга болж, өмнөх сараас 20.3 (18.2%) мянган хүнээр өссөн байна.

ЗУРАГ 2. ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн




Төмөр замын тээврийн орлого 2022 оны эхний улиралд 145.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 46.7 (24.3%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Энэхүү бууралтад жонш, жоншны баяжмал, төмрийн хүдрийн тээвэрлэлт буурсан нь нөлөөлсөн байна.

Төмөр замын тээврийн орлого 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 7.6 (16.3%) тэрбум төгрөгөөр өсөж 54.5 тэрбум төгрөг болжээ.

**Агаарын тээвэр**

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны эхний улиралд 2.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (3.5 дахин) мянган тонноор өссөн байна.

ЗУРАГ 3. АГААРЫН ТЭЭВРЭЭР ТЭЭСЭН АЧАА, сараар, тонн




Агаарын тээврээр 2022 оны эхний улиралд дотоодод 4.0 тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 2.3 (2.4 дахин) тонноор өссөн байна.

Мөн олон улсад тээсэн ачаа 2.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.9 (3.5 дахин) мянган тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2022 оны 3 дугаар сард 841.1 тонн болж, өмнөх сараас 80.6 (10.6%) тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд олон улсад тээсэн ачаа 80.3 (10.6%) тонноор өссөн нь нөлөөлсөн байна.

ЗУРАГ 4. АГААРЫН ТЭЭВРЭЭР ЗОРЧИГЧИД, сараар, мянган хүн



Агаарын тээврээр зорчигчид 2022 оны эхний улиралд 130.5 мянга (давхардсан тоогоор) болж, өмнөх оны мөн үеэс 105.3 (5.2 дахин) мянган хүнээр өссөн байна.

Агаарын тээврээр зорчигчид 2022 оны 3 дугаар сард 49.5 мянга болж, өмнөх сараас 9.5

(23.8%) мянган хүнээр өссөн байна. Энэхүү өсөлтөд Оюутолгой, Истанбул, Сөүл, Токио чиглэлийн зорчигчид өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2022 оны эхний улиралд 69.8 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 51.6 (3.8 дахин) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Оюутолгой чиглэлийн зорчигчид 44.8 мянга, Тавантолгой чиглэлийн зорчигчид 3.0 мянга, Ховд чиглэлийн зорчигчид 2.0 мянган хүнээр тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2022 оны эхний улиралд 60.7 мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 53.7 (8.7 дахин) мянган хүнээр нэмэгдсэн байна. Энэхүү өсөлтөд Истанбул чиглэлийн зорчигчид 18.5 мянга, Сөүл чиглэлийн зорчигчид 12.6 мянга, Анталя чиглэлийн зорчигчид 3.0 мянган хүнээр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2022 оны эхний улиралд 51.0 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 21.5 (72.6%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Харин агаарын тээврийн орлого 2022 оны 3 дугаар сард өмнөх сараас 459.7 (2.8%) сая төгрөгөөр буурч, 16.0 тэрбум төгрөг болжээ.

## Тооцох аргачлал:

**Ачаа эргэлт:** Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.

**Зорчигч эргэлт:** Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.

**Шилжүүлсэн тонн километр:** Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.

**Тээврийн орлого:** Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа өртгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



## Эх үүсвэр:

ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн сарын мэдээ

## Мэдээлэл авах холбоос:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

## Дараагийн мэдээ тархаах хуваарь:

2022 оны 5 дугаар сарын 15

Эдийн засгийн статистикийн газрын  
дарга А.Дэмбэрэл  
Утас: (976-11)-329271

Эдийн засгийн статистикийн газрын  
ахлах статистикч О.Мандахзориг  
Утас: (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212